



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/153

Хажуу шинэ-Ус

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.8 дахь хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн А/165 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын А/331 тоот захирамжыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд үхэр сүргийг 2024 оны 05 дугаар сарын 20-ний өдрөөс эхлэн 25 хоногийн хугацаанд бүрэн хамруулахыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч (Д.Амгалан)-д үүрэг болгосугай.

2. Малчин мал бүхий өрхөд зарлан мэдээлэл хүргэж сумын үхрийг бүрэн хамруулахыг 1 дүгээр багийн Засаг дарга (Б.Мөнхдэлгэр), 2 дугаар багийн Засаг дарга (М.Амарзаяа), 3 дугаар багийн Засаг дарга (Н.Энхтайван) нарт даалгасугай.

3. Дархлаажуулалтын ажилд хяналт тавин мэргэжлийн арга зүйгээр хангаж үр дүнг тайлагнаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (А.Бямбадорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Б.ДАВААСҮРЭН

482401053